

**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

**Огноо: 2019.01.24**

**ХАРЪАЛАЛГҮЙ АХМАД НАСТНУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ БЭЛГИЙН БАГЦ  
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: ХАРЪАЛАЛГҮЙ АХМАД НАСТНУУДАД ХҮНДЭТГЭЛ  
ҮЗҮҮЛЭХ БЭЛГИЙН БАГЦ НИЙЛҮҮЛЭХ**

**Төслийн дугаар: БХР/ХХҮГ/2019/02**

НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА  
ХАРЪЯАЛАЛГҮЙ АХМАД НАСТНУУДАД САР ШИНИЙН БАЯРААР ХҮНДЭТГЭЛ  
ҮЗҮҮЛЭХ БЭЛГИЙН БАГЦ НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН УРИЛГА

1. Огноо: 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр
2. Гэрээний дугаар: БХР/ХХҮГ/2019/02
3. Санхүүжилтийн эх үүсвэр: Нийгмийн халамжийн сан
4. Нийт төсөв 15.000.000
5. Тендер шалгаруулалтын нэр: Харъяалалгүй ахмад настнуудад сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлэх бэлгийн багц нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
6. Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь эрх бүхий тендерт оролцогчдыг 2019 онд Баянхонгор аймгийн харъяалалгүй ахмад настнуудад сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлэх бэлгийн багц нийлүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах тухай битүүмжлэл бүхий тендер ирүүлэхийг урьж байна.
7. Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.
8. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (Тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.
9. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба 0 төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ
10. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагыг дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Эрүүл мэндийн болон худалдаа үйлчилгээний чиглэлээр үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээтэй байна. /Хуулбарыг ирүүлнэ/
- Сүүлийн 3 жилийн ажлын туршлагатай, үйлчилгээгээрээ иргэдэд танигдсан ААН байна./Байгууллагын танилцуулгыг ирүүлнэ/
- Нийлүүлэх багцын үнэ, нэр төрлийг тодорхой заасан жагсаалтыг нэмэлт тайлбарын хамт ирүүлнэ.
- Багцыг олон тоогоор нийлүүлэхдээ хугацааны хүлээлт, чирэгдэл үүсгэхгүй байх чадвартай /1500 ширхэгээр/
- Нийлүүлэх барааны чанар, хадгалалтын хугацаа, сав баглаа боодлыг нийлүүлэгч өөрөө хариуцна.

- Татвар төлөхтэй холбоотой баримт материалиуд бүрэн, татварын өргүй байна.

11. Нийглүүлэх багцын үнэ-10.000 төгрөг

- ✓ **Сүү /Хайрцагтай байх ууттай биш/ эсвэл** Чацаргана /найруулж хэрэглэхээр/
- ✓ **Цаг тооны бичиг /Өргөн хэрэглэгддэг/**
- ✓ **Чихэр /ууттай/**
- ✓ **Хийцтэй цай**
- ✓ **Уут, шошго**

12. Тендерийг 2019 оны 01 дүгээр сарын 31 -ны 11:00 минут-аас өмнө Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 202 тоот өрөөнд хүлээн авна. Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 11:30 минут-т нээнэ

13. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй

14. Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцно

15. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Утас 70442923, 88087662

Вэб сайт: Bayankhongor. Hudulmur-halamj.gov.mn

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Байгууллагын гэрчилгээний хуулбар;   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>14</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| <b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>      | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.   |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>• Татвар төлөгчөөр бүртгэлтэй ААН байна.</li> <li>• Аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ</li> <li>• Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар /Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хүнсний дэлгүүрийн худалдаа эрхэлдэг байх/</li> <li>• Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монгол банкны тодорхойлолт эсхүл харилцагч бүх банкнаас ирүүлэх</li> <li>• Харилцагч Татварын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолтыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан e-balance-аас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/</li> <li>• Шүүхийн байгууллагаас сүүлийн 3 жилтэй холбогдох тодорхойлолт ирүүлэх.</li> <li>• Шүүхээр шийдвэрлэгдсэн өртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх.</li> <li>• Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, татварын тайлан, туршлагын мэдээлэл, танилцуулга</li> <li>• Сүүлийн 2 жил /2017, 2018/ оны борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн дундаж нь санал болгож үнийн дүнгийн 70 хувиас багагүй байх байна.</li> <li>• Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 60%-иас багагүй байх.</li> <li>• Харилцагч Нийгмийн даатгалын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолтыг гаргаж ирүүлэх. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/</li> <li>• 2018 онд хийсэн ижил төстэй ажлын гэрээний хэрэгжилтийн талаар захиалагч байгууллагаас тодорхойлолт авч ирүүлэх.</li> <li>• Тендерт шалгарсан тохиолдолд нийлүүлэгч нь өөрийн зардлаар барааг хүлээн авах газарт хүлээлгэн өгөхөө албан бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>• Үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл</li> <li>• Хүнсний бүтээгдхүүнийг хадгалах хамгаалах орчин нөхцөлөө хэрхэн бүрдүүлж ажилладаг тухай холбогдох мэдээлэл</li> <li>• Жин хэмжүүрээ баталгаажуулсан тухай баримт бичиг</li> </ul> <p>Жич: Дээрх баримт бичгүүдийн хуулбарыг баталгаажуулсан байна.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  Байгууллагын хаяг: <b>Баянхонгор аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2 давхар 205 тоот өрөөнд (Холбоо барих утасны дугаар 88087662) 2019 оны 01 дугаар сарын 31-ны өдрийн 11 цагаас өмнө.</b></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  <b>2018 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 11:30 минутанд Баянхонгор аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 314 тоот өрөөнд нээнэ</b></p>

<b>ТӨЭЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцаас бүрдэнэ:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Чацаргана /найруулж хэрэглэхээр/ эсвэл Сүү /Хайрцагтай байх ууттай биш/</li> <li>2. Цаг тооны бичиг /Өргөн хэрэглэгддэг/</li> <li>3. Чихэр /ууттай/</li> <li>4. Хийцтэй цай</li> <li>5. Уут, шошго</li> </ol>
-----------------	--

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. **Барааны тодорхойлолт:** Чанар, эрүүл ахуй ,хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан бүтээгдхүүнийг нийлүүлнэ. Хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй бүтээгдхүүн нийлүүлсэн тохиолдолд тендерийн гэрээг цуцлана.
2. **Стандарт:**Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна.Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг мөрдөнө
3. **Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх , хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөл шаардлагыг хангасан бүтээгдхүүн нийлүүлнэ.
- 4.**Бараа хүргэх газар:** Барааг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Чацаргана /найруулж хэрэглэхээр/, Сүү /савтай/	<i>хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан, стандартад нийцсэн бүтээгдэхүүн байх</i>	1500	Ш	Баянхонгор аймгийн ХХҮГ	2019-02-01	2019.02.28	
Цаг тооны бичиг	Өргөн хэрэглэхээр байх	1500	Ш	Баянхонгор аймгийн ХХҮГ	2019-02-01	2019.02.28	
Чихэр /ууттай/	<i>хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан, стандартад нийцсэн бүтээгдэхүүн байх</i>	1500	Ууттай	Баянхонгор аймгийн ХХҮГ	2019-02-01	2019.02.28	
Уут, шошго	Өнгө үзэмжтэй байх	1500	Ш	Баянхонгор аймгийн ХХҮГ	2019-02-01	2019.02.28	



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |       |  |
|---|-------|--|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>1</b> жил байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>14</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын тушаалаар баталсан барааг хүлээж авах комисст тоо ширхэг, зураг, баглаа боодолтойгоор гэрээ байгуулсанаас хойш 5 хоногын дотор хүлээлгэн өгнө.  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br><br>Дээрх баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>5.1 Баталгаат засварын хугацаа 1 жил байна  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн <b>100<sup>1</sup></b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup></b>                  | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>Нэг долоо хоногт 0.5 хувь</b><br><br>Алдангийн нийт дүн: <b>Гэрээний үнийн дүнгийн 10 хувь</b>  |

<sup>1</sup>Ихэнхтохиолдолд 100 хувьбайна. Шаардлагатайболтөлбөрийнхуваарийгөөрчилнө.

<sup>2</sup> Ихэнхтохиолдолд, нэгдолоохоногтоногдуулахалдангигэрээнийүнийн алдангийннийтдүнггэрээнийүнийндүнгийн 10 хувиастустусхэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.ы

<sup>3</sup> Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

<sup>4</sup> Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*